

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанаас сумдын ИТХ-ындарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын сургалтыг зохион байгууллаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлж, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн бие даан шийдвэрлэж, үр дүнтэй ажиллаж, 2018 оны ажлын амжилтаараа шалгарсан сумдын шагналыг гардуулан өглөө. Нэгдүгээр байранд Бигэр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба, Хоёрдугаар байранд Есөнбулаг, Чандмань сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба, гуравдугаар байранд Жаргалан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба тус тус шалгарсан байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Дэлгүүрийн эздийн холбоо болон бусад холбогдох төрийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, үйлчилгээний чанар стандарт, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах нөхцөл шаардлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тулгамдаж байгаа асуудлын талаар харилцан санал солилцож нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлэгт аймгийн төв болон сумдад согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 50 орчим хүн оролцлоо.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05-р сарын 16-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор “Архигүй-Алтайчууд” хөтөлбөрийг батлан 2018-2020 оны хооронд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

- Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх;

- Архинд донтох өвчин эмгэгийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулах

- Архинаас татгалзсан, эмчлэгдэж эрүүлжсэн хүнийг нийгэмшүүлэх, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх;

- Архидан согтуурснаас нийгэмд учрах гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид тавих хяналт, нийгмийн хариуцлагыг сайжруулах зэрэг үндсэн 5 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Архидалтаас үүдэлтэй гэмт хэрэг, аваар осол, аливаа хор уршгаас урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хууль хэрэгжүүлэх ажилд түлхэц болохуйц ажил боллоо.

"Монгол Улсын 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийгдэж байгаа Говь-Алтай аймгийн төвд дулааны станц барьж ашиглах

төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн танилцуулга, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2019.03.15-нд зохион байгууллаа.

"Хүүхэд хамгаалал-Эрсдлээс сэргийлэх нь" сургалт ГХУСА33-ийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Прокурорын газар, Боловсрол, соёл урлагийн газар хамтран энэхүү сургалтыг аймгийн хэмжээнд анх удаагаа өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулж буйгаараа онцлог ба нийт 18 сум, аймгийн төвийн сургуулиудын 100 орчим байрын багш, жижүүрүүд хамрагдлаа. Тус сургалтыг аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал нээж, багш сурган хүмүүжүүлэгчид, боловсрол, хууль, цагдаа, эрүүл мэндийн салбарын төлөөлөл илтгэл тавьж, заавар зөвлөгөө өглөө.

ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ ХХААХҮЯ, ОБЕГ-ын албаны хүмүүс, ЗГХЭГ-ын реферэнт нар 21 аймгийн удирдлагуудтай цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, аймгуудын тулгамдаж буй асуудлаар цахим хурлаар санал солилцлоо.

Аймгийн "Удирдах ажилтны зөвлөгөөн- 2019" арга хэмжээ 3 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Алтай хотноо зохион байгуулагдаж тус зөвлөгөөнд Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн С.Цэдэндамба, Хүн, ам орон сууцны тооллогын Улсын комиссын нарийн бичгийн дарга А.Амарбал, аймгийн удирдлагууд, хэлтэс, агентлагуудын дарга нар, бүх сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нар, и-оффис программыг төрийн байгууллагуудад нэвтрүүлэхтэй холбогдуулан тус системийн ашиглалтын онцлог, давуу тал, үр дүнгийн талаар мэдээлэл хийх зорилгоор "Анарсистемс"ХХК-ийн захирал М.Угтахбаяр нар нийт 80 гаруй удирдах албан тушаалтан оролцож, санал бодлоо солилцож зөвлөлдсөн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Тус зөвлөгөөний үеэр:

- ❖ Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, агентлаг, албадын дарга нарын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажууллаа.
- ❖ Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээг орон нутагтаа амжилттай хэрэгжүүлэн, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтээрээ манлайлж, 2018 оны ажлаараа тэргүүлсэн агентлаг, сумдад батламж гардуулав.
- ❖ Цагдаагийн газар 2018 оны ажлын гүйцэтгэлээр тэргүүлсэн бол Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар тус, тус удаалсан байна.
- ❖ Сумдаас Бигэр сум "Тэргүүн" батламжийг хүртэж Тонхил, Жаргалан сумд удаах байруудыг эзэлсэн байна.
- ❖ Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагууд 2018 онд хийсэн ажлын тайланг танилцуулж, аймгийн Засаг дарга 2019 онд хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон цаашид анхаарах асуудлуудын талаар удирдлагуудад үүрэг, чиглэл өгч зөвлөгөөнд орлцогчид төрийн албан хаагчийн тангаргийг уншсанаар зөвлөгөөн амжилттай өндөрлөлөө.

Ерөнхий сайдын өгсөн 15 заалт бүхий үүрэг, даалгаврыг удирдлагуудад танилцуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан арга хэмжээг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх хэлтэс, агентлагууд байгууллага, сумдад хүргүүллээ.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 03 дугаар сарын 26-ны өдрийн 1/594 дугаар албан бичгээр, орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөнд Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/594 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүллээ.

Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339, 340 дүгээр тогтоолоор жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх 7 хоногийн Пүрэв гарагт гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, зарлан мэдээлэх “Амжиж анхааруулах тогтолцоо”-ны дадлага сургалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Еөнбулаг сумын 4-р цэцэрлэгийг нүүлгэн шилжүүлж, аймгийн АДБАЧ-дээр аврах, нүүлгэн шилжүүлэх үзүүлэх сургалт хийлээ.

“Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн-2019” арга хэмжээний үеэр Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс аймгийн Засаг даргын сум, агентлагийн дарга нартай 2018 онд байгуулсан гэрээний биелэлт болон сум, агентлагийн 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг ирүүлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл хийлээ.

Мөн тус хэлтэс “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагналт” сэдэвт чадавхжуулах сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Чандмань, Эрдэнэ сумдын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн 52 албан хаагчийг хамруулан зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2019 оны А/90, А/91 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Насан туршийн боловсролын төвийн нэр бүхий албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны 03 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Дарив сумын Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тус тус хяналт-шалгалтын ажлыг гүйцэтгэж, үр дүнг танилцууллаа.

Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон хэтийн төлөв байдлыг тодорхойлох, бодлогын баримт бичиг боловсруулах, эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэх зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх арга зүйн сургалтыг 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн судалгаа хийх ажлын хэсгийг байгуулж, чиг үүргийг нь тодорхойллоо.

Есөнбулаг сумд 4-р сургуулийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хэсэг болон Засаг даргын дэргэдэх зөвлөл хуралдаж тус сургуулийн сургалтын үйл ажиллагааг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлэхээр шийдвэрлэлээ.

Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэний нийгмийн байгууллагын нэгдсэн зөвлөл, Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд хамтран “Буянтай ээж-2019” ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 19 дэх удаагаа амжилттай зохион байгууллаа.

Энэ үеэр хөдөлмөр зүтгэлээрээ нутгаа хөгжүүлж, үр хүүхдээ өв тэгш хүмүүжүүлж, Алтай нутгийн зон олондоо хүндлэгдсэн Гүнсэгийн Цэвэлмаа, Түдэжавын Должмаа, Дүгэржавын Ичинхорлоо, Түдэвийн Цэдэв, Чимэдцэрэнгийн Цэрэнсодном, Намсрайн Мөнгөнхуяг, Шагжийн Загдсүрэн, Даянгийн Амгалан, Шагдарын Дулмаа нарт “БУЯНТАЙ ЭЭЖ-2019” Өргөмжлөлийг хүндэтгэн гардуулаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд дээрх нэр бүхий 9 ээжид “Байгаль нуур-Итгэлд хамба”-д аялах эрхийн бичгийг илгээж мэндчилгээ ирүүлснийг бие төлөөлөгч Б.Эрдэн-Очир гардууллаа. Түүнчлэн аймгийн Цэргийн штабаас 5-с дээш хүүхэд нь цэргийн алба хаасан Буянтай ээжүүдэд хүндэтгэл үзүүллээ.

УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд, аймгийн Засаг дарга нарын санаачилга ивээл дор сумдын шилдэг ардын авъяастнуудын “Аялгуу дуурьсалтай-Алтай нутаг” нэгдсэн тоглолтыг 2019 оны 03 дугаар сарын 08-ны өдөр Ардын дуу бүжгийн Алтай чуулгад амжилттай зохион байгууллаа. Уг тоглолтонд 18 сумын 50 гаруй ардын авъяастнууд уртын дуу, гоцлол дуу, ардын дуу, нийтийн дуу, ерөөл, бүжиг биелэлгээ, хөгжмийн гоцлолуудын төрлөөр оролцлоо. Тус наадмын шилдэгүүдийг тэргүүн байр, дэд байр, гуравдугаар байр, тусгай байр 2, хамгийн өндөр настай оролцогч гэсэн төрлүүдээр шалгаруулж урамшууллаа. Оролцогчдын хамгийн өндөр настай нь 74 настай, хамгийн залуу оролцогч нь 16 настай байлаа.

Аймгийн шилдэг 9 эмэгтэйг шалгаруулж 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр “Гоо марал-2019” гоо бүсгүй арга хэмжээн дээр аймгийн Засаг даргын өргөмжлөл, гарын бэлгээр шагналаа.

2019 оны 03 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд аймгийн төвийн 9 цэцэрлэгийн үдийн хоолны чанар, хадгалалттай танилцлаа.

Сумдын удирдлагуудад эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах талаар нөлөөллийн сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөлдлөө. Тус сургалтад аймгийн удирдлагууд, Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нар нийт 73 хүн оролцлоо.

“Соёлын ажилтны анхдугаар зөвлөгөөн”-ийг 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд аймгийн удирдлагууд, Боловсрол соёл урлагийн газрын дарга, соёл хариуцсан мэргэжилтэн, аймгийн соёлын байгууллагын бүх албан хаагч нийт 180 гаруй хүнийг хамрууллаа.

Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан -2017 “Хүчирхийллийн нүцгэн үнэн” сургалтад хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн Ц.Сонинцэцэг, НҮБ-ийн төслийн ажилтан В.Нанжид нарыг хамрууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/593 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Аймгийн төвийн албан байгууллагын дарга эрхлэгч нарын шуурхай зөвлөгөөн 03 дугаар сард 3 удаа хуралдаж аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ зохион байгуулагдсан ажлуудын талаар болон цаашид төлөвлөж буй арга хэмжээнүүдийг тухай бүр танилцуулан Орон нутгийн өмчийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хууль эрх, зүйн хэлтсийн дарга Д.Баттайван- Шударга өрсөлдөөнт хэрэглэгчийн төлөө газрын

ажлууд болон “Архигүй-Алтайчууд” хөтөлбөрийн талаар товч мэдээлэл өгч, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Байгальмаа Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Эрдэнэ-Очир, Боловсрол соёл, урлагийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Онцгой байдлын алба, Мэргэжлийн хяналтын газар, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар 2019 онд хийх ажлын талаар тус тус мэдээлэл хийлээ.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран 9 төрлийн уралдаан тэмцээн зохион байгууллаа. Үүнд: “Дартс”, “Биллярд”, “Сагсан бөмбөг”, “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй 2 төрлөөр, буудлагын тэмцээнийг 3 төрлөөр, хүчний 3 төрөлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, “Марш-Тактик”-ийн тасгийн аврага шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгууллаа

Монгол цэргийн өдөр зэвсэгт хүчний 98 жилийн ой, Алтай хотын нэрэмжит Есөнбулаг сумын аварга шалгаруулах сумын харцага, начин цолтой болон залуу бөхчүүдийн барилдааныг 2019 оны 03 дугаар сарын 17-ны өдөр аймгийн БТСГ-ын спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус барилдаанд сумын харцага цолтой 6 бөх, сумын начин цолтой 11 бөх, цолгүй залуу бөх 15 нийт 32 бөх 3 хэсэгт хуваагдан тойрон барилдаж 3 зооноос 12 бөх шигшээ барилдаанд шалгаран барилдаж эхний 8-н байр эзлүүлж сумын заан 1, сумын харцага 1, сумын начин цол 1 тус тус хүртлээ.

Зэвсэгт хүчиний 98 жил, Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан Монгол Улсын баатар М.Жанчивийн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүллээ.

Зэвсэгт хүчний 98 жил, Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан тэмцээн, уралдаануудын нийлбэр дүнгээр Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн хамт олон тэргүүлж шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдсан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/45 дугаар Захирамжийн дагуу сумдын 3415,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад 516,0 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд 8463,6 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн олголоо.

Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн тайланг аймгийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх МСҮТ-ийн чиглэлийн 125мм голчтой 400 метр цэвэр усны шугам шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн материал байхгүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Баян-Уул сумд инженерийн хийцтэй худаг гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт нэг ч оролцогч материал ирүүлээгүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 50 ортой шинэ төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт “Чоногол трейд” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хөхморьт сумын Ёслол хүндэтгэлийн өргөө барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотын нийтийн тээврийн 2 автобус засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх өвс тэжээлийн агуулах барих /Тайшир сумын Далан баг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Дарив сумын сургуулийн хөл бөмбөгийн талбай байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендер байхгүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх ГБХЗХГ-аас 18 дугаар байрны урд хүртлэх ариутгах татуургын шугам /200мм голчтой 350 метр шугам солих/-ын ажилд “Дэвжих Очир” ХХК гүйцэтгэгчээр шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг газар дээр нь очиж нүд үзэн, шалган зааварчлах, үнэлэлт дүгнэлт өгөх, өмч эзэмшлийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулах удирдамж гарган газрын даргаар батлуулан удирдамжид заасан хуваарийн дагуу аймгийн төвийн орон нутгийн өмчит 10 байгууллагад ажиллаад байна.

Орон нутгийн өмчийн мэдээ тайлан, төрийн болон орон нутгийн өмчит 60 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний тайланг хянан хүлээн аваад байна.

Дахин дуудлагын худалдааг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хууль журмын дагуу зохион байгууллаа. Дуудлагын худалдаагаар Есөнбулаг сумын 5-р цэцэрлэгийн хуучин барилга, байгууламж /эм импексийн залгаа хэсэг/-ийг худалдан авахаар 2 иргэн оролцож 72400,0 мянган төгрөгөөр хувьчлахаар боллоо.

Орон нутгийн өмчийн мэдээ тайлан, төрийн болон орон нутгийн өмчит 60 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний тайланг хянан хүлээн аваад байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээлэлжүүлэх системд орон нутгийн өмчит 60 байгууллагын тайланг нэгтгэн ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардаар санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын 4-р сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх тухай, хөрөнгө акталж, үнэ тогтоон худалдан борлуулах тухай, худалдах хөрөнгийн жагсаалт баталж, доод үнэ тогтоох тухай, хөрөнгө акталж данснаас хасахыг зөвшөөрөх тухай, дахин дуудлагын худалдаа явуулах тухай асуудлуудыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн мэдүүлээд байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Цээл сумын Эрүүл мэндийн төвийн гадна тохижилтын ажлын нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд 134 захирамж гаргалаа. Үүнээс 94 захирамжийг байнгын хяналтад авч харьяа агентлаг газар, хэлтэст картлан хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна.

“Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн-2019” арга хэмжээний үеэр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт Эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийдвэрлэх тухай хууль, хууль, тогтоомж гарын авлага ном, Хоршооны тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, бичиг уурхайг зохион байгуулалтад оруулах тухай гарын авлага, Авлигын тухай хууль, Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага, ХАСХОМ-н бүртгэл, хяналт тавих тухай ЭБАТ-д зориулсан гарын авлага, Үндсэн хууль, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тайлбар судалгааны ном зэрэг нийт 442 ширхэг тараах материалыг олголоо.

Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 39 иргэнд мал тооллогын болон цалин, тушаалын лавлагаа олгож, Архивын тасгийн сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсрууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгаас “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл хангах, баримт бичгийн стандартын бүрдэл хангалт, архивын баримт бүрдүүлэх” сэдэвт чадавхжуулах сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Эрдэнэ, Чандмань сумын төрийн албан хаагчдад зохион байгууллаа.

Сумдын Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн ажилтнуудад 3 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд “Баримт бичгийн стандартын бүрдэл хангалт, архивын баримт бүрдүүлэх, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, улсын үзлэгийн бэлтгэл хангаж ажиллах талаар сургалт хийлээ.

Аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өссөн дүнгээр гарсан 14 хэргийн газрын үзлэгт оролцож ажилласан байна. Үүнээс хүн амь учралын 5, хулгай 1, зам тээврийн осол 4, бусад 4 удаа тус тус оролцож, нийт 390 гэрэл зургаар бэхжүүлэн ажиллаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шинээр батлагдсан төрийн албаны тухай хууль, Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шинжлэх, устгах журам баримт бичгийн стандарт гэсэн сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийж гүйцэтгэж ажиллалаа. Тайлант сард Төрсний бүртгэл-302, Гэрлэлтийн бүртгэл-53, үрчлэлтийн бүртгэл-8, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-16, нас баралтын бүртгэл-76, шинээр олгосон иргэний үнэмлэх-664, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн бүртгэл-52, аймаг доторх шилжилт хөдөлгөөн-115, иргэдэд олгосон лавлагаа-571 тус тус хийгдэж, мэдээллийн санд 1286 ХААТР маягт оруулсан байна. Мөн шинээр мөрдөгдөж байгаа хуулийн талаарх брошур, гарын авлагыг хийлгэж иргэдэд тараан, үйлчилгээний зааланд байрлуулан сурталчилж байна.

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 659 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэв. Үүнээс газраас бусад үл хөдлөх болон газар өмчлөх эрхийн хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 108, бусад эрхийн бүртгэл 551, өмчлөх эрхийн 187 гэрчилгээ олгосон.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулиуд, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, хуулийн этгээдийн нэр олгох журам, лавлагаа олгох журам, хувийн хэрэг хөтлөх журам болон байгууллагын стандартыг мөрдөн ажиллав.

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийв. Тайлант хугацаанд шинээр 6 бүртгэл хийгдсэн байна. Үүнд төрийн бус байгууллага-1, компани-3, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллага-1, Хадгаламж зээлийн хоршоо-1

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын ШШГБ-ын албан хаагчдад сургалт зохион байгуулах “Хөтөлбөр батлах тухай” тушаалын дагуу 2018-2019 оны албаны сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг, мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлж, хөрвөх чадвартай хүний нөөц бэлтгэх давтан сургах хүрээнд боловсруулж батлуулан ажиллаж байна.

Нийт алба хаагчдын дунд зохион байгуулсан хичээл сургалтыг багцлан нийт 50 асуулт бүхий тест, монгол хэлний дүрмийн сорил бүхий цээж бичгийн шалгалтыг авсан.

Шалгалтад нийт 26 алба хаагч хамрагдан оролцсон бөгөөд дундаж үнэлгээ 86,7 хувьтай байна.

Мөн аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба “Хүүхэд гэр бүл, залуучууд хөгжлийн газар”, “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”, “Насан туршийн боловсрол олгох төв”, Хилийн цэргийн 0214 дүгээр ангитай хамтран ажиллах гэрээг байгуулан байгууллага тус бүрээр хийх ажлын төлөвлөгөөг хамтран баталж, “САХИЛГА ХАРИУЦЛАГА, МАНЛАЙЛАЛ- МАНАЙ БАЙГУУЛЛАГА” –д сэдэвт зөвлөгөөнийг 2019 оны 03 дугаар сарын 12-ний өдөр зохион байгуулан ажиллалаа.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/402 тоот албан бичгээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлэв.

Ариутгал, халдваргүйтгэлийн аян зохион байгуулах удирдамж болон мал эмнэлгийн тасгийн тархварзүйч, улсын байцаагчийн ажлын байрны чиг үүрэг, 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

Мал эмнэлгийн газрын дарга, Сумын засаг дарга, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал нар гурвалсан гэрээ байгууллаа.

“Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын А\111 дүгээр захирамж гаргаж сумдад хүргүүлээ.

Малын эмийн сангуудын нөөцийн судалгаа, нүүрс ус, эрдэс витамин дутагдлаар өвчилсөн Шарга, Чандмань, Бигэр, Дэлгэр, Есөнбулаг сумдын малын судалгааг гаргаж Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үйлчилгээний хөлсний урьдчилгаа 40 хувь буюу 114220,0 төгрөгийг 57 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид олгосон.

Биокомбинат ТӨААТҮГ-аас шөвөг яр өвчний 200,000 тун вакциныг татан авч сумдын мал эмнэлгийн тасгуудад хуваарийн дагуу олгож байна.

Цогт, Тайшир, Баян-Уул сумдаас галзуу өвчний шинжилгээнд дээж ирсэнд иммунофлуоресценцийн аргаар шинжлэхэд Цогт, Тайшир сумын дээжнээс галзуу өвчин нь оношлогдож, Баян-Уул сумын дээжнээс галзуу өвчний үүсгэгч илрээгүй. Хариуг тус сумдын мал эмнэлгийн тасагт хүргүүлж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Шарга, Халиун, Дарив сумдаас ирсэн 15 зулбадаст хээл хаялт сувайралтанд нөлөөлдөг өвчний шинжилгээг микроб өсгөвөрлөх аргаар хийхэд эерэг урвалтай дээж илрээгүй.

“Малчдад ойрхон - Малын эмч нар” сэдэвт малын эмч нарын нэгдсэн зөвлөгөөнийг 03 дугаар сарын 22-нд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Мал эмнэлгийн ерөнхий газраас Мал эмнэлгийн хяналт шалгалт, хорио цээр, эрсдлийн үнэлгээний газрын дарга Б.Болдбаатар, МЭТ, МЭҮН, орон нутаг хариуцсан мэргэжилтэн Д.Эрхэмбаатар, Мал эмнэлгүүдийн дундын хоршооны хяналтын зөвлөлийн дарга Ц.Зинамидар, Борлуулалтын менежер Э.Мөнгөн-Эрдэнэ, Биокомбинат ТӨААТҮГ-ын дэд дарга С.Тэсхуяг, аймгийн удирдлага, сумдын мал эмнэлгийн тасаг, сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн төлөөлөл, нийт 110 хүн оролцлоо.

“Хөдөө аж ахуй-тогтвортой хөгжлийн үндэс” сэдэвт Хүнс хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн зөвлөгөөн 2019 оны 03 дугаар сарын 28-нд зохион байгуулагдаж “Мал эмнэлгийн газрын 2018 оны ажлын үр дүн, 2019 онд хамтран хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хүргэлээ.

ТАВ.ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

2019 онд аймгийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас” зээл авах хүсэлтэй иргэн, ААН-ээс ирсэн сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээр 4, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр 2, арьс шир боловсруулах чиглэлээр 3, туслах аж ахуйн чиглэлээр 2, хог хаягдлыг боловсруулах чиглэлээр 2, газар тариалангийн чиглэлээр 1, хүнсний үйлдвэрийн чиглэлээр 4, чулуу бутлах болон боловсруулах үйлдвэрийн 2, дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 2, тавилгын үйлдвэрлэлийн чиглэлээр 2, блокны үйлдвэрлэл 2, авто засварын үйлчилгээний чиглэлээр 2 нийт 32 төсөлд 1644,1 сая төгрөгийн зээл авах хүсэлтэй төслүүдийг хүлээн аваад байна.

Тус төслүүдийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлагын дагуу төслийн бүрдэл, тооцоо, дүгнэлтийг шалган төсөл сонгон шалгаруулах хурлаар хэлэлцэхэд бэлэн болоод байна.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

АЗДТГ, ЭМГ хамтран ДЗМОУБ-ын дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг “Инээмсэглэл-Эерэг хандлага” уриан дор зохион байгууллаа. Зөвлөгөөнд нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны төв, зооноз өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 1000 гаруй ажилтны төлөөлөл болох удирдах ажилтнууд оролцож 2018 оны ажлаа дүгнэж, цаашдын төлөвлөлтөө хэлэлцлээ. Эрүүл мэндийн байгууллагуудаас 2018 оны ажлын гүйцэтгэлээр “Маш сайн” үнэлэгдэж тэргүүн байрыг Төгрөг сумын сум дундын эмнэлэг, дэд байр Уламжлалт анагаах ухааны төв, “Сайн” үнэлэгдэж гутгаар байрт Цээл сумын эрүүл мэндийн төвүүд тус тус шалгарлаа. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтээр:

-“Эхийн эндэгдэл гаргалгүй, 0-5 насны хүүхдийн эндэгдлийг бууруулан” ажилласан хамт олноор Нэгдсэн эмнэлэг

-“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 98.1 хувьд хүргэн ажилласан хамт олноор Шарга сумын эрүүл мэндийн төв

-Жирэмсний эхний 3 сартайд 100 хувь хяналтанд ажилласан хамт олноор Баян-уул сумын сум дундын эмнэлэг

- Элэгний В, С вирусийн эрт илрүүлгийн үзлэгийг манлайлан ажилласан хамт олноор Гуулин тосгоны эрүүл мэндийн төв

-Эрүүл мэндийн даатгалыг -Иргэн бүрт жилийн ажлын багцыг амжилттай хэрэгжүүлсэн хамт олноор Энх-Алтай ӨЭМТ

-Гэрийн идэвхитэй үзлэгийг зорилтот түвшинг давуулан биелүүлсэн хамт олноор Бигэр сум дундын эмнэлэг

-Даралт ихдэх өвчин, чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтыг зорилтот түвшинг давуулан биелүүлсэн хамт олноор Тонхил сумын эрүүл мэндийн төв

-Орчин үеийн дэвшилтэт технологийг тусламж үйлчилгээндээ амжилттэй нэвтрүүлсэн хамт олноор Эрүүл Ирээдүй мэс заслын эмнэлэг тус тус шалгарлаа.

Тархвар судлалын 11 дүгээр долоо хоног буюу 2019 оны 03 дүгээр сарын 18-ны байдлаар аймгийн хэмжээнд амбулаторийн 2788 үзлэгээс 194 буюу 7%-ийг томуу, томуу төст өвчин эзэлж, өмнөх долоо хоногоос 3.9%-иар буурсан. Яаралтай тусламжийн 263 дуудлагын 49 буюу 18.6% нь томуу томуу төст өвчин гэж оношлогдсон байна. Томуугаар өвчлөгсдийн 95.3% нь 15, үүнээс 74,5%-ийг 4 хүртэлх насныхан эзэлж байна. Томуу, Томуу төст өвчний үеийн талаарх шуурхай мэдээг

өдөр бүрийн 07 цагт нэгж байгууллагуудаас авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс хуралдаж, 27 хүүхдийн асуудлыг шийдвэрлэлээ.

ДЗМОУБ-ын дэмжлэгтэйгээр Тайшир сумд “Иргэдийн дуу хоолой аргачлал” сургалт, Тайшир сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд хяналт үнэлгээ хийх чиглэлээр эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд ажиллан мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Сумдын лаборант нарыг чадавхижуулах дадлага хосолсон сургалтыг ДЗМОУБ-ын дэмжлэгтэйгээр 2019 оны 3 дугаар сарын 5-10-нд зохион байгуулж 15 мэргэжилтэнг хамрууллаа.

Улсын хэмжээнд 21 аймагт пневмококк болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлын хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албатай хамтран 2019 оны 03 сарын 18-нд Эрүүл мэндийн газрын НЭМТ-ийн дарга болон холбогдох мэргэжилтнүүд, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч, халдвар судлагч, сум дундын эмнэлэг, сум тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмчлэгч эмч, ахлах сувилагч, вакцинолог сувилагч гэсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй нийт 90 гаруй мэргэжилтнийг хамруулсан 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

“Архигүй Алтай” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 20 ажилтанд “Халдварт бус өвчнөөс сэргийлье” сургалтыг зохион байгууллаа.

Нэгдсэн эмнэлгийн 82 сувилагчид “Халдварт бус өвчнөөс сэргийлье” сургалтыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлаа хэлэлцэх зорилготой “Уулзалт-14” шуурхай зөвлөгөөнийг 2019 оны 3 дугаар сарын 15-нд зохион байгуулж нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн төлөөллүүд оролцож, 14 хоногийн мэдээ, цаашид анхаарах асуудлаа хэлэлцлээ.

“Аюулгүй, ухаалаг бараа бүтээгдэхүүн” нээлттэй өдөрлөгт оролцож, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг сурталчилж, иргэдэд витамин, амин дэмээр үйлчиллээ.

Тархвар судлалын 11-р 7 хоногийн байдлаар гахай хавдар 1, гэдэсний халдвар 1, салхинцэцэг 1, цочмог элэгний үрэвсэл 1 нийт 4 тохиолдол бүртгэдэж ХӨСҮТ-д EWAR-аар мэдээллээ.

Цагдаагийн газартай хамтарсан зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд баривчлагдсан 5 иргэнд бэлгийн замаар дамжих халдварын талаар сургалт зохион байгууллаа.

ЭХЭМҮТ-өөс 2019 оны 3 дугаар сарын 15-17 ны өдрүүдэд зохион байгуулсан “Хүүхдийн амь тэнссэн төлөвийн тулгамдсан асуудлууд-II” сургалтанд ДЗМОУБ-ын дэмжлэгтэйгээр сум дунд болон сумын эрүүл мэндийн төвийн хүүхдийн тусламж

үйлчилгээ хариуцсан 18 эмч, АНЭ-ийн хүүхдийн эмч, хүүхдийн зөвлөх эмч, ЭМГ-ын мэргэжилтэн гэсэн нийт 21 хүний бүрэлдэхүүдтэйгээр оролцлоо.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг ханган гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилыг Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газрын ахлах дэслэгч Л.Отгонхишигтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Дадлага сургуулилтанд Эрүүл мэндийн газрын 22 албан хаагч оролцлоо.

2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Эх хүүхдийн эрүүл мэнд” нөлөөллийн сургалтыг сумын Засаг дарга нар, Засаг даргын Тамгын газрын дарга нар, эрүүл мэндийн төвийн дарга нар нийт 67 хүнд хийлээ.

ДОЛОО.БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

БСУГ-аас ЭЕШ-ын бэлтгэлийг эрчимжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа 3 сарын аяны хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалттай 10 судлагдахуунаар “ЭЕШ-2019” урьдчилсан сорилго шалгалтыг 2019 оны 03 сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгууллаа. **Сорилгод 510 хүүхэд хамрагдлаа.**

“Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”-ын салбар дундын 11 чиглэл бүхий нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж БСУГ, ЭМГ, ЦГ, ГБХЗХГ-ын хамтран зохион байгуулах ажлуудыг баталж сургалтын байгууллагуудад хүргүүллээ.

Тайшир, Жаргалан, Хөхморьт, Баян-Уул сумын сургуульд зөвлөн туслах ажлаар гадаад хэлний хамтарсан болон сайжруулсан 14 хичээл явуулсан байна.

Аймгийн БСУГ англи хэлээр бүтээлчээр сэтгэн бичих "Creative Writing" уралдааны 1-р шатыг 9-12-р ангийн 2800 гаруй сурагчийг орлцуулан зохион байгуулж сургууль бүрээс шалгарсан 87 сурагч аймгийн уралдаанд оролцлоо.

2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл 02 дугаар сарын 14-нээс 04 дүгээр сарын 15-ны хооронд хийгдэж байна. Энэ онд өдрийн ангиар 510, дүйцсэн хөтөлбөрөөр 108 хүүхэд 12-р анги төгсөнө. Өнөөдрийн байдлаар 474 хүүхэд бүртгүүлээд байна.

2019 оны журам, сургалтын материалыг сургуулиудад хүргүүлэн сургалтын менежерүүд 533 багш, 489 эцэг, эх, 787 сурагчид мэдээлэл сургалтыг хийсэн байна.

Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Тайширт зөвлөн туслах ажиллаж мэргэжил, хичээл сонголт, элсэлтийн ерөнхий шалгалтыг зөвлөгөө мэдээлэл өгөх мэдээлэл сургалт хийж, 240 сурагч, 98 эцэг эхэд зөвлөгөө мэдээлэл өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 21 аймгийн аварга шалгаруулах Футзалын U-16 насны “Үндэсний цом 2019” хөлбөмбөгийн тэмцээн 2019 оны 02-р сарын 23-ны өдрөөс 03-р сарын 04-ний өдрүүдэд тоглолтууд Дархан-Уул аймагт

амжилттай зохион байгуулагдаж, “ҮНДЭСНИЙ ЦОМ 2019” тэмцээний тоглолтууд амжилттай явагдаж дүнгээ гаргалаа.

Говь-Алтай аймгийн шигшээ баг 8 тамирчин, 1 дасгалжуулагч нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй оролцож ирлээ. Тэмцээний зардалд 1600000 мянган төгрөг зарцуулсан байна. Тэмцээнд Есөнбулаг сумын 1-р сургуулийн сурагч Д.Далайцэрэн, Т.Цогномлха, Н.Цэцэнбэрх, М.Дашдэмбэрэл, Т.Пүрэвдорж Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн сурагч А.Бат-Эрдэнэ, Н.Сод-Эрдэнэ, Б.Билгүүн шигшээ багийн дасгалжуулагч СМ Л.Хатанбаатар нар Говь-Алтай аймгийн шигшээ багт багтан оролцсон байна.

Говь-Алтай аймгийн шигшээ баг шилдэг 8-т багтан шагналт 5 дугаар байрт шалгарсан өндөр амжилт гаргалаа. Мөн шилдэг мэргэн бууч төрөлд Д.Далайцэрэн 13 гоол оруулан 4-р байрт шалгарсан байна.

БСУГ-ын мэргэжилтнүүд Гуулин, Дэлгэр сумд зөвлөн туслахаар ажиллалаа.

Бага, дунд боловсролын чанарын үнэлгээний судалгааг 2019 оны 03 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд 23 сургуулийн 9 дүгээр ангийн 877 сурагч, түүвэрт хамрагдсан Есөнбулаг сумын 1, 3 дугаар сургууль, Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 3, 9, 10 дугаар ангийн сурагчдыг хамруулан зохион байгууллаа.

Сумдад ажиллах мэргэжилтэн, багш нарын хуваарийг Боловсрол, соёл урлагийн газрын даргын тушаалаар баталж, унаа машинаар ханган шөнө, орой явахгүй байх, осол авааргүй ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

2019 оны 03 дугаар сарын 30-ний өдөр “Соёлын ажилтний анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд 180 гаруй соёлын ажилтан оролцож санал бодлоо солилцлоо.

НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын_ хэлтэс 2019 оны 03 дугаар сард 2742899.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого оруулахаас 2755469.96 мянган төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 100.45 хувиар биелүүллээ.

Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 03 дугаар сарын 1нд, тэтгэмжийг сард нь багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа. Өндөр насны тэтгэвэр авагч 5123 хүнд 5626751.8 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авагч 1883 хүнд 1240521.8 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 392 хүнд 267182.1 мянган төгрөг, цэргийн тэтгэвэр авагч 122 хүнд 290362.8 мянган төгрөгийн тэтгэврийн тус тус олголоо. Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 186 хүнд 208037.4 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 142 хүнд 26417.2 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 56 хүнд 56000,0 мянган төгрөгийг, ажилгүйдлийн даатгалын

сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 113 даатгуулагчид 56017.33 мянган төгрөгийг тус тус олголоо. ҮОМШӨ-ий даатгалын сангаас хөгжлийн бэрхшээлтэй 28 хүний тэтгэвэрт 18388.84 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 6 хүнд 3352.6 мянган төгрөг, зарцуулжээ.

03 дугаар сарын 01-15-ны хооронд Сайн дурын даатгалын байцаагч Н.Эрдэнэ-Очир, Орон тооны бус байцаагч Г.Элбэгдорж нар аймгийн худалдааны байгууллагууд, зах дээр очиж нийгмийн даатгалын хууль, сайн дурын даатгал, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын талаарх гарын авлагыг хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ард иргэдэд нийтдээ 250 хүнд мэдээлэл хүргэж ажиллалаа.

Тайлант сард Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурал 2 удаа хуралдаж нийт 106 хүн сунгагдаж шинээр 19 хүн орж, 5 хүнийг буцаасан байна.

Тайлант сард аймгийн хэмжээнд 18 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна.

2019 оны 03 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст нийт дараах аж ахуй нэгж байгууллагаас сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирсэн байна.

1. Ажлын байрын захиалга

- ✓ Хүслийн наран” ХХК гутлын цехэд гуталчин
- ✓ 3-р сургууль тогооч
- ✓ “Алтайн хүрд” ХХК гагнуурчин, цахилгаанчин
- ✓ Ардын дуу бүжгийн алтай чуулга жолооч- нярав
- ✓ “Алтайн хүдэр” ХХК-д гэрээгээр ажил гүйцэтгэдэг “Цагаан марбл” ххк-д дараах ажлын байрууд зарлагсан байна.

Үүнд:

- ✚ өрмийн машины оператор
 - ✚ зүсэгчийн машины туслах
 - ✚ экскаваторын оператор –сат 385с
 - ✚ ковшийн оператор- сат 988н
 - ✚ усны машины жолооч- с ангилалтай байх
 - ✚ цахилгаанчин
 - ✚ механик – хятад техник засаж байсан туршлагатай байх
 - ✚ засварчин – гагнуур хийдэг байх
- ✓ “Орд харш” ххк- 20 айлын орон сууц барих ажилд туслах ажилтан авна.
 - ✓ “Дашваанжил” ХХК- эмэгтэй түгээгч

Ирүүлсэн дээрх ажлын байрны захиалгуудыг аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, хэлтсийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангаас нийт 71 иргэнийг санал болгосон байна.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдээс авах СХТТ 15 дахь удаагийн шалгалтын бүртгэлийг 03 сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 28 иргэнийг бүртгэж, бүртгэлийг холбогдох газарт хүргүүлсэн байна.

3. Говь- Алтай аймагт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийх арга зүйн сургалтыг 2019.03.05-нд зохион байгуулав.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

2019 оны 3 дугаар сард дараахь тэтгэвэр тэтгэмжийг иргэдэд олгосон.

Халамжийн тэтгэвэр 1370 иргэнд 230.6 сая.төг

• Нөхцөлт мөнгөн тэтгэмж 1125 иргэнд 70.0 сая.төг

- Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1007 иргэнд 82.7 сая.төг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 79 иргэнд 12,6 сая.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 106 иргэнд 7,5 сая.төг
- Алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 4,8 сая.төг
- Өрх толгойлсон эхийн тэтгэмж 126 иргэнд 139,1 сая төгрөг
- Алдарт эхийн одонтой 8 иргэнд 0,8 сая.төг
- Цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 2840 иргэнд 140.4 сая.төг төгрөг тус тус олгосон.

- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 29 албан хаагчид оролцлоо. Энэ ажлын хүрээнд байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож, албан хаагчдын утасны жагсаалтыг шинэчиллээ. Мөн ОБГ-аас зохион байгуулсан газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, өөрийгөө болон бусдыг аврах, анхны тусламж үзүүлэх сэдэвт сургалтад тус газрын албан хаагчид хамрагдлаа.

Дадлага сургалтад хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих 15 төрлийн зүйлийг жагсаалын дагуу бүрдүүлэн бэлэн байдлын дохиогоор гарч Монгол улсын баатар Жанчивын талбайд гарч жагслаа.

ЕС. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлан дэлгэрүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх, ирээдүйн мастеруудыг бэлтгэх, хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг дэмжих зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 10,11-ний өдрүүдэд “**ЦОДГОР ХҮҮ**”-2019 өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 4 насны ангиллаар зохион байгуулж тэмцээнд Алтай, Баян-Уул, Бигэр, Дэлгэр, Шарга, Хөхморьт, Жаргалан, Есөнбулаг сум, Алтай хотын 1,2,3,5,6 дугаар цэцэрлэгийн нийт 105 тамирчин өрсөлдлөө.

Бүтэн өнчин хүүхдүүдэд тулгамдаж буй асуудал, хэрэгцээг тодорхойлох зорилгоор Есөнбулаг сумын бүтэн өнчин 21 хүүхдийг хамруулан 2019 оны 01-р сарын 11-нд уулзалт зохион байгуулж, 4 хүүхдийн ар гэрт нь Дэлхийн Зөн ОНХХ-өөс 100,000 төгрөгийн хүнсний талон олгуулахаар шийдвэрлэлээ.

Залуу эмэгтэйчүүдийн дуу хоолой уулзалтыг “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” төрийн бус байгууллагатай хамтран “Eearcompass” уулзалт арга хэмжээг зохион байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн хэрэгцээ шаардлага, хамтарч ажиллах нөөц боломж, эцэг эхчүүдийн зөвлөлийн холбоог идэвхжүүлэх зорилгоор эцэг эхчүүдийн уулзалт зохион байгууллаа.

Сумдын олон нийтийн цагдаа, цагдаагийн /30/ ажилтнуудад Хамтарсан багаар ажиллах арга зүй, холбон зуучлах үйлчилгээний талаарх мэдээллийг цагдаагийн газартай хамтран зохион байгууллаа.

Шүүхийн шийдвэрээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан болон албадан хөдөлмөр эрхлэх ялаар шийтгүүлсэн 2 хүүхэдтэй ажиллаж байна.

Есөнбулаг сумын гэр бүлийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж буй зорилтот өрхийн гишүүдэд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ тодорхойлох зорилгоор 8 багийн 85 өрхийг хамруулан уулзалт зохион байгууллаа.

Өрх толгойлсон болон гэртээ хүүхдээ харж суудаг эхчүүдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хөгжүүлэх, амьдрах ухааны боловсрол олгох, Жендэрт суурилсан хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудыг таниулах

зорилгоор Залуу эмэгтэйчүүдэд зориулсан амьдрах ухааны сургалтыг охион байгуулж сургалтад аймгийн төвийн 20 залуу эмэгтэй оролцлоо.

Өсвөр насны хөвгүүдэд хувийн нөөц бололцоогоо нээн илрүүлж хөгжүүлэх, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч бусдыг мэдэрч ойлгодог хувь хүн болон төлөвшүүлэх зорилгоор Аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиудын 8-12-р ангийн гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 24 сурагчид амьдрах ухааны /2 Модул/ сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл, 1 дүгээр цэцэрлэг, Миний нутаг телевизтэй хамтран “Хүүхэд бүр ардын урлагт суралцацгаая” аяны хүрээнд сар шинийн баярын уламжлалт зан үйл, ёс заншлыг хүүхэд, багачуудад сурталчлан таниулах зорилготой “Дөрвөн бэрх” телевизийн нэвтрүүлгийг бэлтгэн хүргэлээ.

Хүүхэд, гэр бүлтэй холбоотой 3 дуудлага ирсэн бөгөөд харьяа хамтарсан баг руу шилжүүлэн аргазүйгээр ханган зөвлөн туслан 2 кейсийг шийдвэрлэлээ. Мөн 1 хүүхдийн үрчлэлтийн асуудлыг холбон зуучлан шийдвэрлүүллээ. Зөвлөгөө үйлчилгээ хүссэн 6 хүнд зөвлөн тусаллаа.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш, ажилтан суралцагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээллэх, сурталчлах гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлах урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 106 хүүхэд, 36 багшид хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, 2018 онд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл, “Цахим орчны зөв зохистой хэрэглээ” сэдвээр сургалт мэдээллийн ажлыг хийлээ.

Өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн боловсрол олгох, харилцаа, хандлага, жендерийн талаарх мэдээлэл түгээх, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Гэгээн хайрын баяр”-ын өдрийг тохиолдуулан **"Мэдлэгтэй Валентин"** өдөрлөгийг Залуучуудын хөгжлийн төв, "Мэдлэгийн өртөө" клубтай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 10-12-р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Нийт 45 сурагч хамрагдсан. Үр дүн: Өсвөр үеийнхний бие махбодийн хэвийн өсөлт хөгжил, бэлгийн бойжилтийн онцлог ялгаа, жендерийн талаарх ойлголтыг хөгжөөнт тоглоомын аргаар танин мэдэж "Мэдлэгийн өртөө" клубийн сурагчид “Хайр” сэдвээр илтгэл тавилаа.

Хүүхдийг зургийн арга ашиглан харилцааны онцлогийг нь тодорхойлж, цаашид өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болгох зорилгоор “SMART TEENAGERS сургалтыг МСҮТ-ийн эрсдэлийн үнэлгээ өндөр өсвөр насны 37 хүүхдэд” зохион байгууллаа.

Авто машин согтуугаар жолоодон зөрчил үйлдэн баривчлагдсан 3, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэн баривчлагдсан 3 иргэнд гэр бүлийн гэр бүлийн харилцаа зөрчлийг шийдвэрлэх арга зам сэдвээр сургалт зохион байгууллаа.

Зорилтот өрхийн гишүүдэд амьжиргааны чадвар олгох зорилгоор Жаргалант, Түмэн багийн 9 иргэнд зүү ороох оёдлын сургалтыг зохион байгуулж байна.

Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хуралдаан 2019 оны 02 сарын 27-ны өдөр 69 хувийн ирцтэй хуралдаж 2019-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталлаа. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлөөс гарсан төлөвлөгөөний дагуу Эерэг хандлага-Эрүүл залуу хүн аяны нээлтийг 04 сарын 01-нд хийж 18 сум 2 тосгонд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Өсвөр насны хүүхдэд тулгарах сэтгэл зүйн онцлог, өөрчлөлтийн талаар өсвөр үеийнхэнд таниулж, энэхүү өөрчлөлтөөс үүдэлтэй харилцаанд учрах бэрхшээлийг даван туулах, сайжруулах арга замын талаар зохих мэдлэгтэй болгох, өсвөр насны

хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчил, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хандлага зан үйлийг өөрчлөхөд нөлөөлөх зорилгоор "Өсвөр үеийнхний харилцаа" сэдэвт сургалтыг Ерөнхий боловсролын II сургуулийн 15-17 насны 170 хүүхдэд 26 сургагч багш бэлтгэн батламж гардууллаа.

Өсвөр үе, залууст өөрөө болон бусдад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХ-ын талаарх мэдлэг, чадварыг эзэмшүүлж шинэлэг хэлбэрээр мэдлэг боловсрол олгох мөн "Залуучууд хөгжлийн төв"-ийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, дээрх асуудалд өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 02 сарын 23,24-ний өдрүүдэд үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.

"Нар хүссэн Яргуй" уянгын драмын жүжгийг тоглолоо

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, үлгэр дууриалал болсон манлайлагч эмэгтэйчүүдийнхээ үгээр дамжуулж, өсвөр насны охид бүсгүйчүүдэд ухаарал хайрлах зорилгоор "Ээжүүдээ сонсьё" хэлэлцүүлгийг Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл, Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, Хөөрхөн зүрхнүүдийн аянтай хамтран зохион байгууллаа. "Ээжүүдээ сонсьё" хэлэлцүүлгийн зочноор ИННЗ-ийн тэргүүн Г.Ундрам, МУГЖ дуучин З.Тэрбиш, эмч С.Жаргахсайхан, АБТ-ний ажилтан багш С.Мөнхбаяр, бизнес эрхлэгч Б.Алтантуяа, Хаан банкны эдийн засагч Н.Пүрэвсүрэн нар оролцлоо. Хэлэлцүүлэгт Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн охид, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч бүсгүйчүүд зэрэг 240 гаруй эмэгтэй оролцлоо.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн орчинд хүүхэд нэг бүрийн оролцох эрхийг тэгш хангах, өсвөр насны хүүхдүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд болон бэлгийн амьдралтай холбоотой чадваруудыг эзэмшүүлэх, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчил, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөллийн хор уршгийг таниулах, учрах эрсдэлээс өөрсдийгөө хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох зорилгоор "САЙН ЗӨВЛӨГЧ" ХҮҮХДЭЭС ХҮҮХДЭД ЧИГЛЭСЭН ХАМГААЛАЛ, ОРОЛЦООНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГИШҮҮН ХҮҮХДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА" сургалтыг 1,2,3, Хантайшир эрдэм цогцолбор сургуулийн 420 хүүхдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, оролцоо, цахим орчны хэрэглээ гэсэн 3 чиглэлийн хүрээнд Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл, Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн гишүүн сурагчид, Мэдлэгийн өртөө клуб, Y-PEER өсвөрийн сургагч хүүхдүүдтэй хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллага аж ахуй нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөлийг байгуулан ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулж 45 байгууллагын албан хаагч хамрууллаа.

Аймгийн Цагдаагийн газар баривчилгаанд байгаа 8 хүнд "стресс, бухимдал тайлах аргууд" сэдвийн хүрээнд бүлгийн зөвлөгөөг 2019 оны 03 сарын 06-нд зохион явууллаа.

Алтай нутгийнхаа хөгжил цэцэглэлтэд өөрсдийн хувь нэмэрээ оруулж, залуу хойч үедээ хүндлэгдсэн аавуудын төлөөлөл оролцсон "Аавуудаа сонсьё-2019" арга хэмжээг Есөнбулаг сумын ЗДТГ, Үйлвэрчний эвлэлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөл, Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл, Их буудал ХХК-тай хамтран зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд 250 иргэн оролцлоо.

Есөнбулаг сумын "Гэр бүлийг дэмжих хөтөлбөр"-т хамрагдаж буй өрхийн иргэдийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн үнэ цэнийн

талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төрөөс үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл өгөх зорилгоор “Гэр бүлийн өдөрлөг”-ийг зохион байгуулж зорилтот өрхийн 150 иргэн хамрагдлаа.

АРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Шарга сумын улсын аюулгүйн нөөцөөс 300 боодол өвсийг хүлээн авч, 100 боодлыг Хүйсийн говьд байршуулахаар Хөхморьт сум руу ачуулах, Эрдэнэ, Чандмань, Тайшир сумдад хуваарьлах 100 боодол өвсийг аймгийн төв рүү татан төвлөрүүлэх ажлыг, мөн үлдэгдэл 100 боодол өвсийг Шарга сумд байршуулж Монгол бөхөн, харсүүлт зээр төвлөрч буй Олонбулаг, Шаргын зааг Цөлөрхийд, Төгрөгийн хүрэн гол багийн нутгаар тараан байршуулж биотехникийн арга хэмжээг зохион байгууллаа.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хотод “Говийн гайхамшигт зургаа” зохицуулах зөвлөлийн хуралдаан болон бизнес эрхлэгчидтэй санал солилцох уулзалтад аймгаас төлөөлөл оролцлоо. Мөн Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2019 онд “Говийн гайхамшигт зургаа” зохицуулах зөвлөлийг удирдах эрхийг хүлээлгэн өглөө.

Даян Дэлхийн байгаль орчны сан, НҮБХХ-ийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтран “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтийг хангах нь” төслийг тус аймгийн Цогт, Эрдэнэ, Чандмань сумдад хэрэгжүүлж эхлэх гэж байгаатай холбогдуулж төслийн нээлтийн уулзалт, семинарт оролцлоо.

Амьд ертөнцийн тайлан-2018” арга хэмжээг БОАЖГ, ДБХС-ийн Ирвэстэй нутгийн ирээдүй төсөлтэй хамтран 2019 оны 03 дугаар сарын 18-нд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт зохион байгууллаа. Уг арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын 60 албан хаагч, ЕБС-ийн 190 гаруй сурагч оролцлоо. “Амьд ертөнцийн тайлан-2018” ажлын хүрээнд ЕБС-ийн 7-9 ангийн сурагчдын дунд “Амьд ертөнц миний нүдээр” гар зураг, уран илтгэлийн уралдаан мөн Эко клубуудын дунд “Амьд ертөнцөө хайрлацгаая” аяныг өрнүүлж шалгарсан шилдэг сурагч, эко клубыг шагнаж урамшуулав.

Дэлхийн усны өдөр”-ийг жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр тэмдэглэж цэвэр усны ач холбогдолд дэлхий нийтийн анхаарлыг хандуулах, усны нөөцийн тогтвортой менежментийг сурталчилан өнгөрүүлдэг уламжлалтай билээ.

Энэ жил НҮБ-аас “Цэнгэг ус-тэгш хүртээмж” уриан дор зохион байгуулахаар зарласан бөгөөд тус газар нь Эрүүл мэндийн газар, Хүйсийн говь-Цэцэг нуур, Хяргас нуур-Завхан гол, Алтайн өвөр говийн сав газрын захиргаадболон “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ хамтран олон талт ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Үүнд:

➤ Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллага /Өрхийн эмнэлэг/-уудаар дамжуулан “Дэлхийн усны өдөр”-ийг сурталчилан зүй зохистой хэрэглээ, усны аюулгүй байдлын талаар 290 гаруй иргэдэд сургалт, сурталчилгааг 2019 оны 03 дугаар сарын 20-25-ны хооронд зохион байгуулж байна.

➤ 2019 оны 03 дугаар сарын 25-нд Шинэ-Алтай захын гадаа талбайд Аймгийн төвийн 8 багийн иргэдийндунд “Дэлхийн усны өдөр”-ийг сурталчлах өдөрлөг, тэмцээн уралдаан зохион байгуулж идэвхтэй оролцсон иргэдэд 48 ширхэг стандартын усны сав өгнө.

➤ Ерөнхий боловсролын сургуулиудын байгаль орчин, эрүүл мэндийн

чиглэлийн эко клубын 210 сурагчид, эрүүл мэндийн багш, эмч нарт өртөөчилсөн сургалт хийж шүдугаах, гаругаах үедусыг зөв зохиостой хэрэглэх мөн түүний үнэ цэнэ, ундны усны аюулгүй байдлыг хангах талаар сургалт зохион байгууллаа.

➤ Цогт, Цээл, Эрдэнэ, Алтай, Бугат, Төгрөг сумдын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Ус ба би” сэдэвт гар зураг, “Ус ба хүний эрх” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарлан явуулж байр эзэлсэн сурагчдыг шагнаж урамшуулав.

➤ Есөнбулаг сумын томоохон ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагын 50 төлөөлөлтэй 2019 оны 03 дугаар сарын 22-нд Ентүм ХХК-ий хурлын танхимд уулзалт зохион байгуулж усныхаалаг, зүйзохиостой хэрэглээ, хэмнэлттэй ашиглах техник, технологийг нэвтрүүлэх, усны нөөцийг нэмэгдүүлэх, тэгш хүртэхийн ач холбогдлыг талаар ярилцаж мэдээллээ солилцлоо.

➤ Усны чиглэлээр төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэгч салбарын байгуулагууд болон усны мэргэжлийн байгууллага, хангагч, ашиглагч байгуулагуудын дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг 2019 оны 03 дугаар сарын 23-ний өдөр зохион байгуулж 1-р байрт: “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, 2-р байрт ЗДТГ-ын баг хамт олон, 3-р байрт: БОАЖГ-ын баг шалгарч медаль, бренд спорт хувцас хийлгэх эрхийн бичгээр шагнууллаа.

Монголын аялал жуулчлалын холбоо, БОАЖЯ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ITM-2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 03 дугаар сарын 29-31-ний хооронд Улаанбаатар хотод зохион байгуулагдах арга хэмжээнд аймаг орон нутгаа сурталчилан оролцохоор бэтгэл ажлыг хангалаа.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран Дэлхийн дулаарал, уур амьсгалийн өөрчлөлтийн эсрэг нэгдэх “Эх дэлхийн цаг-2019” арга хэмжээг 2019 оны 03 дугаар сарын 30-нд Алтай хотод “Хуванцараас татгалзъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хүүхэд багачуудад олон талт арга хэмжээ зохион байгуулахаар удирдамж, төлөвлөөг боловсруулж, бэлтгэл ажлыг хангаад байна.

АРВАН НЭГ. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Улс төрийн ууган хүчин МАН-ын 98 жилийн ой, эх орончдын өдөрт зориулсан үндэсний бөхийн барилдаан боллоо. Тус барилдаанд аймаг, сумын цолтой 16 шилдэг бөх барилдлаа.

“Мөрөн-Алтай” ХХК-ын нэрэмжит шилдэг багуудын волейболын тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 2-3-нд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд эрэгтэй, эмэгтэй 15 багийн 120 тамирчин оролцлоо.

Улс төрийн ууган хүчин МАН-ын 98 жилийн ой, эх орончдын өдөрт зориулсан сагсан бөмбөг, волейболын тэмцээн болж 28 багийн 245 тамирчин хамрагдлаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр мартын 8-нд зориулсан волейболын тэмцээн болж 7 багийн 56 тамирчин оролцлоо.

АРВАН ХОЁР. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолтой холбогдуулан Говь-Алтай аймгийн МХГ-ын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс даавуун торыг хэрэглээндээ хэвшүүлэхийг уриалж challenge-ийг зохион байгууллаа.

Хяналт шалгалтын баримт бичгийн стандартын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Хуулиар эрх олгогдсон 23 улсын байцаагчид тусгайлсан хөтөлбөрийн дагуу зөвлөгөөнийг зохион байгуулж, Зөрчлийн тухай хууль болон салбарын хууль,

“Мэргэжлийн хяналт, шалгалтын ерөнхий шаардлага стандарт”, 2019 онд баталсан Засгийн Газрын тогтоол, журмуудаар сургалт зохион байгуулав.

Онцгой байдлын ерөнхий газар, аймгийн ОБГ-аас зохион байгуулсан “Говь-Алтай аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааны арга зүй” сургалтад 4 албан хаагч оролцож, Цогт, Цээл, Халиун, Есөнбулаг, Алтай, Бугат, Тонхил, Дарив, Тайшир, БаянУул, Жаргалан, Дэлгэр зэрэг сумын гамшгийн эрсдэлийг үнэлэв.

Боловсролын хяналтаар:

Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн 10 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан зөвлөмж хүргүүлэн ажиллав.

Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтаар:

Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Есөнбулаг сумд ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах, худалдаалах үйл ажиллагааг “Шинэ-Алтай” ХХК-ын худалдаа үйлчилгээний төвд эрхлэж буй 3 иргэнд төлөвлөгөөт хяналтыг 1.18 кодтой хяналтын хуудсаар хийхэд бүгд бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллуулахаар 22 заалт бүхий 3 албан шаардлагыг дээрх иргэдэд хүргүүлж шалгалтыг шилэн хяналтад шивж баталгаажуулав.

Хүүхдийн эрүүл ахуйн хяналтаар:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Гуулин тосгоны цэцэрлэгт “Цэцэрлэгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар шалгалт хийхэд шаардлага хангаагүй 235 оноо авч эрсдэл үүсэх магадлал 41%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт 59% байв.

Гуулин тосгоны ерөнхий боловсролын сургуулийг “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад шаардлага хангаагүй 130 оноо авч эрсдэл үүсэх магадлал 33%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт 62% байв. “Дотуур байрны эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад шаардлага хангаагүй 200 оноо авч эрсдэл үүсэх магадлал 45%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт 57% байв.

Орчны эрүүл ахуй, халдвар судлалын хяналтаар:

Гуулин тосгон, Тайшир сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд 1 объект бага, 1 объект дунд эрсдэлтэй үнэлэгдэн улсын байцаагчийн албан шаардлага өгөв.

Гуулин тосгоны ундны усны төв худгийн үйл ажиллагаанд 3.5 хяналтын хуудсаар шалгалт хийн дунд эрсдэлтэй үнэлэгдэн улсын байцаагчийн албан шаардлага өгөв.

Дэлгэр сумын Баян-Өндөр багт шинээр гаргасан худгийн уснаас ирүүлсэн дээжийг МХГ-ын НЛ-д шинжлүүлэхэд магнийн хатуулаг, нянгийн тоо стандартаас их гарсан тул улсын байцаагчийн дүгнэлт гарган хүргүүлэв.

“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын лаборанттай хамтран аймгийн төвийн ундны усны 6 цэгээс дээж авч Нэгдсэн Лабораторид шинжлүүлж байна.

Хүнсний чанар, стандартын хяналтаар:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Гуулин тосгоны цэцэрлэгт “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар шалгалт хийхэд шаардлага хангаагүй 90 оноо авч эрсдэл үүсэх магадлал 31%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт 67% байв.

Гуулин тосгоны ерөнхий боловсролын сургуулийг “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад шаардлага хангаагүй 111 оноо авч эрсдэл үүсэх магадлал 43%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт 53% байв. Есөнбулаг сумын Төгөл шугуй ХХК-ий Буудай хүнсний дэлгүүрт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд хяналтын хуудсаар 135 оноо авч эрсдэл үүсэх магадлал 31%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт 69% байв.

Эмчилгээ, Эм биобэлдмэл, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтаар:

Урьдчилан сэргийлэх хяналтын 01/23 удирдамжийн дагуу “Эм Жи И” эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлгийн үйл ажиллагаанд хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийн арчдас 20, агаарын 6, ариун материалын 3 дээж авч МХГ-ын Нэгдсэн Лабораторид шинжлүүлэхэд эерэг дүнтэй хариу гараагүй. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчдын 8 заалттай албан шаардлага өгөв.

“Энх-Алтай”, “Жаргалан-Алтай”, “Марал-Алтай” өрхийн эрүүл мэндийн төвүүдэд төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн эрүүл зүйн шинжилгээгээр арчдас 20, агаарын 6 сорьц авч Мэргэжлийн Хяналтын Газрын Нэгдсэн Лабораторид шинжлүүлэхэд эерэг хариу гараагүй, хяналтын хуудсаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмж өгөв.

Дэлгэр сумын Баян-Өндөр багт шинээр гаргасан худгийн уснаас ирүүлсэн дээжийг Нэгдсэн лабораторид шинжлүүлэхээр хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд хүн амын суурьшлын бүсийн ундны ус хангамжийн судалгаа гарган МХЕГ-т хүргүүлэв.

Тайшир сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд дунд эрсдэлтэй үнэлэгдэн улсын байцаагчийн албан шаардлага өгөв

Мал эмнэлгийн хяналтаар:

МХЕГ-ын даргын 2019.01.17-ний өдөр баталсан 01/25 дугаар удирдамжийн дагуу Есөнбулаг сумын Оргил багт байрлалтай “Дэвшил-Алтай” ХХК-ий малын эмийн гэрээт борлуулагчийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, “MNTV” телевиз, “Алтай” радиод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт болон зах зээлд нийлүүлэгдэж байгаа малын эмийн зохистой хэрэглээ, худалдаалалт, хадгалалтын талаар ярилцлага өгч ажиллалаа.

Есөнбулаг сумын “Анхилуун арцат”, “Цэргийн булаг”, “Шимт-Олон” ХХК-дын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд МХЕГ-ын даргын баталсан №1.15.1 “Ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээний мал эмнэлгийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар хяналт шалгалт хийж эрсдэлийн бүлгийг тогтооход нэг аж ахуйн нэгжийн мал эмнэлэг 83 оноо буюу 19%-аар бага, хоёр аж ахуйн нэгжийн мал эмнэлэг 130-152 оноо буюу 30-35,5%-аар тус тус дунд эрсдэлтэй үнэлэгдэж, улсын байцаагчийн 35 заалт бүхий 3 хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллалаа. Шарга сумын “Гурван богд хайрхан”, “Индэртийн-Өгөөж” ХХК-дын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд МХЕГ-ын даргын баталсан №1.15.1 “Ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээний мал эмнэлгийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, эрсдэлийн бүлгийг тогтооход 110-116 оноо буюу 26,0-27,0%-аар тус тус бага эрсдэлтэй үнэлэгдэж, улсын байцаагчийн 24 заалт бүхий 2 хугацаатай зөвлөмж хүргүүлэв. Хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний баримт материалуудыг “Шилэн хяналтын систем”-д байршуулан ажиллалаа.

Мал үржлийн хяналтын чиглэлээр:

МХГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр баталсан 08/11 дүгээр хөтөлбөрийн дагуу Шарга сумд үйл ажиллагаа явуулж буй “Үржил-Алтай” ХХК, “Тунгалаг рашаант” ХХК-уудын мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний

нэгжүүд болон иргэн Н.Ганзоригийн өрхийн гахайн аж ахуйд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Үржил-Алтай” ХХК-ий мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжид 7 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Есөнбулаг сумын иргэн Р.Батбаяр, Р.Бурмаа нарын өрхийн гахайн аж ахуйд төлөвлөгөөт хяналт шалгалтыг “Өрхийн гахайн аж ахуйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд Р.Батбаярын өрхийн гахайн аж ахуй 21%-аар бага, Р.Бурмаагийн өрхийн гахайн аж ахуй 42%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэв.

Шалгалтаар илэрсэн дутагдлуудыг арилгуулахаар Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, “Цэргийн булаг” ХХК-ий Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжид албан бичиг хүргүүлж ажиллав.

Есөнбулаг сумын иргэн Ч.Жаргалсайханы өрхийн гахайн аж ахуйд зөвлөн туслах үйлчилгээг “Өрхийн гахайн аж ахуйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үзүүлэхэд 35 оноо буюу 18.4%-аар бага эрсдэлтэй үнэлэгдэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Эрчим хүчний хяналтаар:

2019 оны төлөвлөгөөний дагуу 1 шатахуун түгээх станц цаашид /ШТС/-ын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 16 заалттай албан шаардлага хүргүүлж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, 1 /ШТС/-ын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 9 заалттай зөвлөмж хүргүүлж ажиллав. 1 /ШТС/-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна

Байгаль орчны хяналтаар:

1 аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдлын дагуу Есөнбулаг сумын Индэрт багийн иргэн зөвшөөрөлгүй газар малын сэг зэм хаясан нь хяналт шалгалтын явцад тогтоогдож “Зөрчлийн тухай” хуулиар тус иргэнд арга хэмжээ авч зөрчлийг арилгуулж ажилласан.

“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-т Байгаль орчны хяналт, Хөдөлмөрийн хяналтаар төлөвлөгөөт шалгалт хийгдэж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн хяналтаар:

2019 оны төлөвлөгөөний дагуу “Аяны зам Алтай” ХХК-ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хамтарсан зөвлөмж хүргүүлэв.

Өнө-Алтай ХХК төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид хийж шалгалтаар илэрсэн зөрчилд 9 иргэнд 4425.0 мянган төгрөгийн цалин хөлсийг олгохоор, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод ногдох шимтгэл нөхөн төлүүлэхээр 1017.8 мянган төгрөгийн акт тогтоож шийдвэрлэв.

Дулааны улирал эхэлсэнтэй холбогдуулан барилгын ажил эхлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд МХЕГ-ын даргын 2019 оны 01/40 тоот удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх шалгалт хийж, 2 барилгын компаний барилга угсралтын ажилд ногоон тор татах ажлыг хийлгэв.

2019 оны 1 дүгээр улирлын төлөвлөгөөний дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр “Ентүм трэйвэл” ХХК, “Удмын ундраа” ХХК-ийл үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 2 албан шаардалага хүргүүлэн, 2 аж ахуйн нэгжид 800,0 мянган төгрөгийн торгууль ногдуулж ажиллав.

Авто замын хяналтаар:

Газар гэсэж дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан Улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг гүйцэтгэж, 2 аж ахуйн нэгжид хариуцсан авто замдаа

үзлэг шалгалтыг шуурхай хийж, илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах талаар албан тоот хүргүүлж, шар усны үерээс болгоомжлох, гүүр гарцгүй газраар зорчихгүй байх талаар сэрэмжлүүлэг гаргаж сурталчилгаа хийлээ. Энэ ажлын хүрээнд Алтай хотын төвийн авто зам, үерийн далан, ус зайлуулах байгууламжийн ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэж байна.

Улсын чанартай авто замд байрлах Тайширын 222,3 у/м, Естийн ам, шаргын гатлагын 18,6 у/м төмөр бетон гүүрнүүдийн ашиглалтын байдалд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж байна.

Лабораторийн удирдлагын системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд ХАБҮЛЛ-оос ажлын хэсэг ирж, иж бүрэн компьютер хүлээлгэн өгч, программын сургалт хийснээр LIMS программ нэвтэрч эхлээд байна.

Лабораторид 5 байгууллага, 12 аж ахуйн нэгж, 10 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 11 сорьцод 44 үзүүлэлтээр, унд, ахуйн усны 2 сорьцод 40 үзүүлэлтээр, жимс, жимсгэний 19 сорьцод 22 үзүүлэлтээр, үрийн материалын 2 сорьцод 48 үзүүлэлтээр, төмс, хүнсний ногооны 12 сорьцод 23 үзүүлэлтээр, эмнэлгийн дотоод халдварын арчдасны 40 сорьцод 80 үзүүлэлтээр, агаарын 2 сорьцод 6 үзүүлэлтээр, ариун материалын 3 сорьцод 3 үзүүлэлтээр, арчдасны 80 сорьцод 160 үзүүлэлтээр, ариутгалын бодисын 1 сорьцод 2 үзүүлэлтээр хими, хор судлал, нян судлал, хорио цээрийн шинжилгээ хийхэд эмнэлгийн дотоод халдварын агаарын 1 сорьц 1 үзүүлэлтээр /нянгийн тоо стандартаас 92-оор их/, хүнсний бүтээгдэхүүний 1 сорьц 1 үзүүлэлтээр/стандартаас тослог 2%-аар бага/, унд, ахуйн усны 1 сорьц 2 үзүүлэлтээр /стандартаас нянгийн тоо 27-оор, магнийн хатуулаг 22 мг/л-ээр их/стандартын шаардлага хангаагүй.

АРВАН ГУРАВ. ДЭД ҮТЭЦ, ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Монгол улсын Засгийн Газар болон Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын хөнгөлөлттэй зээлээр Монгол улсын нийт 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах, дулааны станц барих төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний танилцуулга, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгийг БНСУ-ын “Ёошин” консорциум, “ЭкоТрейд” ХХК-тай хамтран зохион байгууллаа.

Бигэр сумын 0.4кВт, 0.22 кВ-ын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэлд захиалагчийн хяналт гүйцэтгэллээ.

Бигэр сумаас Цогт сумыг холбосон 15 кВ-ын ЦДАШ-ыг буулган зөөж, Цогт сумаас Баянтоорой багийг холбох ажлын трасс тохиролцох, ачаалал тооцохоор Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн төлөөлөл, “Алтай-Улиастай ЭХС” ТӨХК-ийн инженер, АЗДТГ-ын төлөөлөл явж судалгаа тооцоолол хийлээ.

Барилга, хот байгуулалтын салбарт:

Барилгынсалбарын УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН болж түүний хүрээнд Оронсууц, нийтийнажахуйнсалбарынудирдахажилтнызөвлөгөөн, Хот, байгуулалт, газрынхарилцаанысалбархуралдаандтөрийнболоннийтийнажахуй, барилгын салбарын төлөөллүүд оролцлоо.

Барилга, байгууламжийн бат бэх найдвэржилын төлөв байдлын мэргэжлийн дүгнэлт гаргах, паспортжуулах ажлын биет үзлэг сургалтад Засаг даргын дэргэдэх Орон тооны бус паспортжуулах зөвлөлийн гишүүдийн төлөөлөлүүд хамрагдлаа.

Улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламжийн зураг төсөв, газрын захирамж, кадастар, техникийн нөхцөлийг холбогдох газруудаас авах ажлууд хийгдэж байна.

Улсын төсвийн 874,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ суманд 100 хүүхдийн цэцэрлэгийг “Хөндлөн чоно” ХХК гүйцэтгэн ашиглалтад орууллаа.

Нийтийн аж ахуйн салбар:

“Тайшир-Алтай” усан хангамжийн төслийг эхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудал цаашид анхаарах асуудлаар Барилга, хот, байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Б.Билэгжаргал, Н.Болорчулуун, аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХ-ийн мэргэжилтэн Ж.Мөнхчимэг, ерөнхий архитектор Б.Бямбадорж, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын дарга С.Булгантамир, зураг төсөв зохиогч “МОГҮМБ констракшн” ХХК-ийн Захирал М.Золбаяр, барилга угсралт, шугам сүлжээний угрсалтыг гүйцэтгэгч “Сайрам булган” ХХК-ийн захирал Хаш-Эрдэнэ болон холбогдох төлөөллүүд хуралдаж тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Иргэн, аж ахуй нэгж байгууллагын 3 газарт магадлан хэмжилт хийж, зургийг Есөнбулаг сумын газрын даамалд хүргүүлээ.

Сумдын даамлуудад 2019 оны 03 дугаар сарын 18-ны 82 тоот албан бичгээр Геодезийн цэг тэмдэгтийн тооллого явуулах, Газар зүйн нэрийг таниулах, сургалт зохион байгуулах, Хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар албан бичиг хүргүүлээ.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт сумдын хэмжээнд одоо мөрдөгдөж байгаа хилийн цэсийн гадна талд болон дамнан олгосон зөрчилтэй нэгж талбарын судалгааг гаргаж байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт 2019.03.06-ны өдрийн 68 тоот албан бичгээр Гудамж, зам, талбайн, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах” журмын төсөлд санал хүргүүлээ.

ГЗБГЗЗГ, Unitel ХХК-тай хамтарч Газрын харилцааны өдөрт зориулсан “Мэдлэгээрээ уралдая” Quiz уралдаанд 3 сарын 01-нээс 10 гишүүнтэй 2 баг оролцуулж, зохион байгуулж ажилласан.

Тонхил сумд Газрын эзэмшигчийн өөрийн хүсэлтээр, эзэмшигч шилжсэн, нас барсан, газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй, хоёр жил дараалан ашиглаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй үндэслэлээр хавсралтад заасан 22 иргэний газар эзэмших эрхийг хүчингүй болгосон

Эрдэнэ сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажилд улсын комисс ажиллаж, үүрэг даалгавар өгч ажилласан.

Аймгийн өндөр барилга, байгууламжийн судалгааг гаргалаа.

Газрын цахим биржийн системд он гарсанаас хойш 71 газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад барьцаалсны бүртгэлийг хийж улсын төсөвт 710,0 мян.төгрөг төвлөрүүлсэн байна.

Дэлгэр, Эрдэнэ, Цээл сумдуудад газар эзэмших эрхийн дуудлага худалдаа зохион байгуулах талаар чиглэл хүргүүлж дэлгэр, эрдэнэ сумдуудад 3 нэгж талбарын 10937 м² талбай бүхий газрын дуудлага худалдаа амжилттай зохион байгуулж 30850,0 мян төгрөг орон нутгийн дансанд төвлөрүүлээд байна. Цээл сумд 5 байршилд дуудлага худалдаа зарласан бөгөөд дуудлага худалдаа явуулах хугацаа болоогүй байна.

Газрын төлбөрийн төлөвлөгөө 409998,2 мян.төг төлөвлөсөн, урьд оны дутуу 6416,5 мян.төгрөг нэмж ноогдуулан төсөвт нийт 416415,2 мян.төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 33836,9 мян.төгрөг улсын төсөвт төлвөрүүлсэн байна. Төлбөрийн биелэлт 8,1 %-ийн биелэлттэй байна.

Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн веб хувилбарт туршилт хийн 10 саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын газар эзэмших эрх шилжүүлэх, газрын хэмжээ өөрчлөх захирамжуудаар гарсан 1 байгууллагад үйлчилгээний зориулалтаар, 6 иргэнд орон сууц, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тус тусгазар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгууллаа.

2018 оны 11 сарын 1-нээс Улсын бүртгэлийн тухай шинэчилсэн хуулийн дагуу Газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх болсон ба Аймгийн улсын бүртгэлийн хэлтэст газар эзэмших хувийн хэргийг цахимаар илгээж нийт нийт 7 нэгж талбар газарт Улсын бүртгэлийн Э-дугаар авсан байна.

Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн вэб системийг улсын хэмжээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан сумдын Газрын даамлуудад Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн вэб системийн сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 14-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 16-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Цаг агаарын хагас хоног, 1, 5, 7 хоног, сарын мэдээ, анхааруулга сэрэмжлүүлэг мэдээ, улирлын төлвийг аймгийн удирдлагууд, Онцгой байдлын хэлтэс, Байгаль орчны газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Алтай нисэх буудал болон бусад аж ахуй нэгж албан байгууллагад албан бичиг болон мэйл хаяг, утсаар тогтмол өгч байна.

Нислэгийн үйлчилгээнд агаарын бодит болон урьдчилсан мэдээг өдөр тутамд, чиглэлийн агаараар нислэгтэй өдөр үйлчилж байна. Миний нутаг, Алтай телевиз, радио мэдээллийн хэрэгслээр цаг агаарын мэдээг тогтмол мэдээлж байна.

Алтай-Улаанбаатар, Таян-Баянхонгор чиглэлийн нислэгүүдэд цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээний хангалт хийлээ.

Тунадас: 18-ны өдөр Есөнбулаг, Тонхил, Цээл 0.0мм, шөнөдөө Есөнбулаг 0.4мм, Тонхил, Бугат 0.2мм, Ажбогд, Цээл 0.5мм, Хөхморьт, Тайшир 0.0мм.19-ний

өдөрЕсөнбулаг 0.0мм, Баянуул 0.8мм, Чандмань 0.3мм, Эрдэнэ 1.0мм цасорлоо. Бусад нутгаар цас ороогүй.

Агаарын температур: Өнгөрсөн 7 хоногтоо хугацааны эхээрАлтайн өвөр говиор өдөртөө 2-8 градус дулаан, шөнөдөө 12-19 градус хүйтэн, хамгийн дулаан нь өдөртөө Баянтоорой 14 градус дулаан, шөнөдөө Баянтоорой 6 градус хүйтэн, бусад нутгаар өдөртөө 2-14 градус дулаанаас 11 градус хүйтэн, шөнөдөө 14-21 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь өдөртөө Цээл 11 градус хүйтэн, шөнөдөө Дарви, Дэлгэр 21 градус хүйтэн байсан бол хугацааны сүүлээр Алтайн өвөр говь болон Хүйс, Шарга, Халиун, Бигэрийн говиор өдөртөө 7-11 градус дулаанаас, 1 градус хүйтэн, шөнөдөө 6-12 градус хүйтэн, хамгийн дулаан нь өдөртөө Баянтоорой 11 градус дулаан, шөнөдөө Алтай 3 градус хүйтэн, бусад нутгаар өдөртөө 6 градус дулаанаас 4 градус хүйтэн, шөнөдөө 10-17 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь өдөртөө Есөнбулаг 6 градус хүйтэн, шөнөдөө Цогт 17 градус хүйтэнбайв. Хамгийн хүйтэн нь өдөртөө Цээл 11 градус хүйтэн, шөнөдөө Дарви, Дэлгэр 21 градус хүйтэн байв.

Салхи: 17-нд Есөнбулагт 15м/с, 18-нд Тонхил, Тайшир 15м/с, Халиун 16м/с, Бугат 23м/с, Шарга 24м/с, 19-нд Халиун,Тоорой 15м/с, Алтайсум, Дарви 16м/с, ТонхилШарга 20м/с, Бугат, Цогт 22м/с хүрч ширүүслээ. Бусад хугацаанд салхи баруунаас секундэд 5-10 метр байв.

Алтай хотын агаарт агуулагдаж байгаа хүхэрлэг хий /SO₂/ болон азотын давхар исэл /NO₂/-ийн хэмжээг 08, 14, 20 цагуудад тогтмол хэмжиж хэмжлийн үр дүнг 10 хоног тутам нэгтгэн УЦУОШТ-ийн цахим хуудсанд байршуулан ард иргэдэд мэдээлж ажилласан. 3 дугаар сарын байдлаар дээрх үзүүлэлтүүд зөвшөөрөх дээд хэмжээнээс давсан тохиолдол гараагүй байна.

Гадаргын усны шинжилгээ 4 дүгээр сарын 01-ээс хийгдэж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах зорилгоор шинжилгээ хийхэд шаардлагатай калибровкуудыг тогтоох ажил хийгдлээ. /нитрит-NO₂, төмөр-Fe/.

СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ТАЛААР:

Алтай сум Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймгийн Алтай телевизтэй хамтран “Одонтой ээж” нэвтрүүлгийг хийж 35 эмэгтэй оролцлоо.

Баян-Уул сум 02-р сарын 26-нд “Тэвэр дүүрэн инээд-Надад нэг илүү байна” тусч сэтгэлийн аянг өрнүүлж нийт цугларсан хандивын зүйлсээ анги бүрээс шалгарсан, улс, бүс, аймгийн хэмжээнд амжилт гаргасан тэргүүний сурагчдадаа урамшуулал болгон гардууллаа. Нийт 48 хүүхдэд бэлгийг гардууллаа. Арга хэмжээнд 72 багш, ажилтан, 560 сурагч, 8 төрийн болон төрийн бус байгууллагын 150 гаруй хүн хамрагдлаа.

Бигэр сумын засаг даргын Тамгын газар, эмэгтэйчүүдийн холбоо хамтран Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд гар бөмбөгийн тэмцээн, буухиа тэмцээн, хоолны үзэсгэлэн, Монгол хувцасны үзэсгэлэнг тус тус зохион байгуулж, “Алтан нутгийн бэрчүүд” урлагийн тоглолтыг амжилттай зохион байгууллаа.

Чандмань сумын Хүүхэд хөгжил хамгааллын бодлогыг боловсруулж, дотуур байрны болон 6,7,8,12 дугаар ангийн сурагчдад “Архи тамхины хор хөнөөл”, “Цахим донтолт”-ын талаар сургалт хийж, нийтээр сургуулийн орчинд ухаалаг утас барихгүй байх талаар багш нараасаа үлгэр дуурайлалтай ажиллахаар болов.

Есөнбулаг сум “Цэвэр орчин-Эрүүл хот” аяныг 04 дүгээр сарын 01-ээс 07 дугаар сарын 1-ийг хүртэл хугацаанд зарлахаар төлөвлөгөө, удирдамж боловсруулан ажиллаж байна.

Шарга сумын хэмжээнд өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан Шарга, Хүйсийн говьд байгаа бөхөн, хар сүүлтэй, цагаан зээр зэрэг амьтаддаа БОАЖГ, ДБХС хамтран өвс, тэжээл, хужир тавьж биотехникийн арга хэмжээг эхлүүллээ.

Тайшир сумын ЗДТГ, цэцэрлэг хамтран “Хүүхэд – Хэрэглэгч” өдрийг хамтран тэмдэглэж сургуулийн хүүхдүүдэд хүнсний эрүүл ахуй, эрүүл мэндэд нөлөөлөх хүнс, хүнсний хугацааг хэрхэн шалгах талаар мөн сумын хэрэглэгчийн эрхийг хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүн, зорилго, бараа бүтээгдэхүүний баталгаат хугацаа түүний ач холбогдлын талаар хэрэглэгчийн эрх зөрчигдвөл хэнд хэрхэн хандаж, эрхээ хамгаалуулах талаар сургалт зохион байгууллаа.

Тонхил сумын Засаг даргын захирамжаар Алтансоёмбо багийн нутаг дэвсгэрт гадны сумаас ирсэн малыг гаргах ажлын хэсэг байгуулагдан тус багийн нутаг дэвсгэрт байгаа адууг албадан гаргаж холбогдох эзэд, малчидтай нь уулзаж 2019.03.15-ны дотор адуугаа гаргасан байх үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Цээл сумын ЗДТГ Дэлхий усны өдрөөр “Ус чандмана эрдэнэ” сургалтыг 37 хүүхэд, 65 иргэнд сурталчилан таниулав.

Цогт сумын ГХУССЗөвлөл, сумын Засаг дарга нар сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлын хэрэгцээнд Мустанг-200 маркын мотоциклын хөрөнгийг шийдвэрлэж хүлээлгэн өглөө.

Төгрөг сум цастай, өвсгүй, хаваржилт хүндрэх төлөвтэй байгаа бөгөөд сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 200ш өвс, 30 уут тэжээлийн нөөцтэй байна. Том малын хорогдол 880, нийт 562 хээлтэгч төллөснөөс төлийн хорогдол-230, бойжиж байгаа 332 төл байна.